

32 ХАРААЛ

Бурхан эдгээрийг үзэн яддаг

3 2.1 Хиймэл шүтээн шүтэх

²¹ЭЗЭН Бурхандаа зориулан босгох тахилын ширээний дэргэд ямар нэгэн модон Ашера шонг бүү босго. ²²Чиний Бурхан ЭЗЭНий үзэн яддаг чулуун баганыг чи өөртөө зориулан бүү босго. (Дэд хууль 16:21-22)

¹“Эргийн орнууд аа. Намайг чимээгүй сонсогтун. Ард түмнүүд хүчээ шинэчлээд урагшлан ирж, ярилцаг. Шүүхэд цөмөөрөө хамт орцгооё.

²Хэн дорно зүгээс нэг хүнийг босгох вэ? Хэн түүнийг үнэн зөв дотор Өөртөө үйлчлүүлэхээр дуудах вэ? Тэр түүний өмнө үндэстнүүдийг тушаан авчирч, хаадыг дардаг. Тэр илдээрээ тэднийг тоос мэт, нумаараа салхинд хийссэн хагд өвс мэт болгов. ³Тэр тэднийг хөөж, урьд хөл тавьж байгаагүй замаар амар тайван өнгөрнө.

⁴Хэн үүнийг хийж гүйцэтгэсэн бэ? Хэн эхнээс нь түмэн үеийг бий болгосон бэ? ЭЗЭН Би бол эхлэлд ч, төгсгөлд ч байна. Би бол Тэр мөн”.⁵Эргийн орнууд үзээд айж, дэлхийн хязгаарууд чичирлээ. Тэд ойртон ирлээ.

⁶Хүн бүр хөршдөө туслан, ах дүүдээ “Зоригтой бай” гэж өгүүлнэ. ⁷Ингэж дархан нь хайлуулагчийг зоригжуулж, антуучин нь дөшчингөө зоригжуулна. Гагнаасны талаар “Сайн байна” гээд тэр түүнийг ганхуулахгүйн тулд хадаасаар бөхөлнө. (Исаиа 41:1-7 АБ 2004)

¹¹Чи тэдэнд “Тэнгэрүүд ба газрыг бүтээгээгүй бурхад газар дэлхийгээс болон тэнгэрүүдийн доороос устах болно” гэж хэл. (Иеремиа 10:11 АБ 2004)

¹Чи өөрийн Бурхан ЭЗЭНд өө сэвтэй, ямар нэгэн согогтой үхэр, хонийг бүү өргө. Учир нь тэр чинь чиний Бурхан ЭЗЭНий өмнө жигшүүрт зүйл юм. ²ЭЗЭН Бурханаас чинь чамд өгч буй хотуудын аль нэгэнд, та нарын дунд суудаг эрэгтэй, эмэгтэй хэн нэгэн хүн Түүний гэрээг зөрчин, ЭЗЭН

Бурханы чинь өмнө муу үйл хийж, ³миний тушаасны эсрэг өөр бурхдад очиж, зарагдан тэдэнд, эсвэл нар, сар, тэнгэрийн алив эрхэст мөргөвөөс ⁴энэ нь чамд мэдэгдэж, чи түүний тухай сонссон бол сайтар шалгаж үз. Хэрэв тэр нь үнэн байгаад, Израильд ийм жигшүүрт хэрэг гарсан гэдэг нь батлагдвал ⁵чи тийм бузар муу хэрэг хийсэн тэр эрийг, эсвэл тэр эмийг хотын дааман хаалга уруу аваачиж, чулуу чулуудаж ал.

⁶Алуулах хүнийг хоёроос гурван гэрчийн амаар алагтун. Харин ганц гэрчийн амаар бүү ал. ⁷Түүнийг алах үед эхлээд түүний эсрэг гэрч нарын гар хүрч, дараа нь бусад бүх хүмүүсийн гарыг хүргэ. Та нар өөрсдийнхөө дундаас муу муухай хэргийг тэгж зайлуул. (Дэд хууль 17:1-7 АБ 2004)

⁹ЭЗЭН Бурханы чинь чамд өгч байгаа тэр газарт чи хүрч очихдоо, тэндхийн үндэстнүүдийн жигшүүрт үйлсийг бүү дуурайгтун. ¹⁰Та нарын дунд, хүү юм уу, охиноо галын дундуур гаргагчид, мэргэ төлөгч, совин тайлагч, ид шидтэн, илбэчин, ¹¹хараалч, сүнс зуучлагч, хар домч, сүнс дуудагч бүү байг. ¹²Эдгээрийг үйлдэгч хэн боловч ЭЗЭНд жигшүүртэй юм. Ийм жигшүүрт үйлээс болж ЭЗЭН Бурхан чинь чиний өмнөөс тэднийг хөөн гаргана. ¹³Чи өөрийн Бурхан ЭЗЭНий өмнө төгс бай. (Дэд хууль 18:9-13 АБ 2004)

⁴Та нар хэнийг шоолж, хэний эсрэг амаа томоор ангайлган, хэлээ гаргана вэ? Та нар тэрслэгчийн хүүхдүүд, худал хуурмагийн үр удам бөгөөд ⁵царс моддын дунд, аливаа саглагар модны дор дүрэлзэн шатаж, хадны хавцал дор, гуу жалганд хүүхдээ алдаг биш үү?

⁶Гуу жалгын гөлгөр чулуунуудын дундах нь чиний хувь юм. Тэд, зөвхөн тэд чиний шавга мөн. Чи тэдэнд ундаан өргөл асгаж, идээн өргөл өргөсөн билээ. Үүнд чинь Би санаа амрах болж байна уу? ⁷Чи өндөр, сүрлэг уулан дээр өөртөө ор засаж, тахил өргөхийн тулд тийшээ гарсан. ⁸Чи хаалга хатавчны ард тэмдэг тавьсан. Үнэндээ Надаас алслан холдсон чи биеэ нүцгэлсэн. Дээш гарч, ороо өргөсгөн, өөрийнхөө төлөө тэдэнтэй тохиролцон, тэдний оронд дурлан, нүцгэн биеийг нь харсан билээ.

⁹Чи хаан уруу тостой очиж, үнэртнээ нэмэгдүүлсэн. Чи элчингүүдээ алс хол газар илгээн, Үхэгсдийн орон уруу

буулгасан. ¹⁰Замын уртад чи ядарсан боловч, “Найдлага тасарлаа” гэж хэлээгүй. Чи хүч тэнхээгээ сэргээн олсон учраас шантраагүй. (Исаиа 57:4-10 АБ 2004)

¹⁶Намайг умартаж, бусад бурхдад тахил өргөн, өөрсдийн гарын бүтээлдээ мөргөсөн тэдний бүх бузар булайгаас болж Би Өөрийн шүүлтийг тэдний дээр тунхаглах болно(Иеремиа 1:16 АБ 2004)

[] Та хиймэл шүтээн гэж юу болохыг мэдэх үү?

[] Хиймэл шүтээн шүтэхийг Бурхан яагаад үзэн яддагийг та мэдэх үү?

[] Хуурамч бурхдын болон тэдний дагагчидын хувь заяаг мэддэг та үү?

[] Дэлхийн хэв шинжийг та дагадаг уу?

[] Хиймэл шүтээн шүтэхийг соёлын боловсролоос ялгаж салгаж ойлгодог уу та?

32.2 Хэл яриа, түүний эсрэг үйл ажиллагаа

⁸Юу гэвэл, Иерусалим бүдэрч, Иуда уналаа. Учир нь тэдний хэл болон үйлс нь ЭЗЭНий эсрэг байж, Түүний сүр жавхланта оршихуйн эсрэг босжээ. (Исаиа 3:8 АБ 2004)

¹²Тэдний найр нь лир, босоо ятга, хэнгэрэг, лимбэ, дарсаар хөгжинө. Гэвч тэд ЭЗЭНий үйлсийг үл анхаарч, Түүний мутрын ажлыг тунгааж бодохгүй. (Исаиа 5:12 АБ 2004)

¹⁶Тэгээд ЭЗЭНээс эмээдэг хүмүүс бие биентэйгээ ярихад ЭЗЭН анхаарал тавин сонссон. ЭЗЭНээс эмээдэг болон Түүний нэрийг үнэлдэг хүмүүсийн төлөө дурсгалын ном Түүний өмнө бичигдсэн билээ. (Малахи 3:16 АБ 2004)

[] Таны юу хэлэх нь таны шүүлтийн хэмжүүрээр тодорхойлогддог гэдгийг та мэдэх үү?

32.3 Бузартсан мөргөл

⁸Хар санаатны өргөл ЭЗЭНий хувьд жигшүүртэй юм. Харин цэх шулуун хүний залбирал Түүний таалалд нийцдэг. (Сургаалт үгс 15:8 АБ 2004)

¹¹ЭЗЭН айлдаж байна.“Та нарын олон тахил Надад юу юм бэ? Би хуцын шатаалт тахилд, бордсон үхрийн өөхөнд бүр цадлаа. Надад бух, хурга, ямааны цус ч таалагдсангүй.

¹²Та нар Миний өмнө үзэгдэхээр ирэхдээ Миний хашааг дэвслэхийг хэн шаардсан бэ?¹³Зохисгүй өргөлөө цаашид бүү авчрагтун. Утлага чинь Надад жигшүүртэй байна. Шинэ сар, амралтын өдөр, цугларалтын дуудлага болох бузар гэм болон ёслолын чуулганыг Би тэвчиж чадахгүй. (Исаиа 1:11-13 АБ 2004)

¹⁰“Миний тахилын ширээн дээр ашиггүй галыг асаахгүйн тулд та нарын дундаас хэн нэгэн нь хаалгуудыг хаагаасай! Би та нарт таагүй байна. Та нарын гараас Би өргөлийг чинь хүлээн авахгүй” гэж түмэн цэргийн ЭЗЭН айлдаж байна.

¹¹“Учир нь нар мандахаас жаргах хүртэл Миний нэр үндэстнүүдийн дунд аугаа байх болно. Газар бүрд Миний нэрд зориулан утлага болон цэвэр идээн өргөлийг өргөх болно. Учир нь Миний нэр үндэстний дунд аугаа болно” гэж түмэн цэргийн ЭЗЭН айлдаж байна.

¹²“Гэвч та нар “ЭЗЭНий ширээ нь бузарлагдсан. Түүний үр жимс, хоол хүнснийх нь хувьд гэвэл тэр нь жигшигдсэн” гэж хэлснээрээ та нар түүнийг бузарлаж байна.¹³Та нар бас “Хараач, энэ нь ямар ядаргаатай вэ” гэж хэлээд, үүнийг зэвүүцэнгүй сэжиглэнэ” гэж түмэн цэргийн ЭЗЭН айлдаж байна. “Та нар хулгайлагдсан, доголон эсвэл өвчтэй амьтныг авч ирдэг. Ингэж та нар өргөл авчирдаг. Түүнийг чинь Би та нарын гараас авах ёстой гэж үү?” гэж ЭЗЭН айлдаж байна. (Малахи 1:10-13 АБ 2004)

³Шударга хийгээд зөвийг үйлдэх нь ЭЗЭНд өргөлөөс ч илүү таалагддаг. (Сургаалт үгс 21:3 АБ 2004)

[] Хэн мөргөлийг бузарладагийг та мэдэх үү?

[] Та мөргөлдөө Эзэнтэй уулзсан уу?

[] Та мөргөлдөө хүлээн зөвшөөрч болохуйц тахилыг авчирдаг уу?

32.4 Хараалыг тунхаглав

⁹Тэгээд Мосе тахилч левичүүдтэй хамт бүх Израильд хандан -Израиль аа, чимээгүй, сонс! Чи өнөөдрөөс ЭЗЭН Бурханыхаа ард түмэн боллоо. ¹⁰Тиймээс өөрийн Бурхан ЭЗЭНий үгийг дуулгавартай дагаж, миний өнөөдөр чамд тушааж буй Түүний тушаал зарлигийг мөрд гэв.

¹¹Мосе мөн тэр өдөр ард түмэнд тушаан ¹²-Та нар Иорданыг гаталж гараад, Симеон, Леви, Иуда, Иссахар, Иосеф, Бениамин овгууд нь ард түмнийг ерөөхөөр Геризим уулан дээр зогсож,

¹³Реубен, Гад, Ашер, Зебулун, Дан, Нафтали овгууд нь хараал хийхээр Ебал уулан дээр зогсоно.

¹⁴Левичүүд бүх Израиль хүмүүст хандан чанга дуугаар ¹⁵“Урчуудын сийлсэн, эсвэл цутгасан шүтээнийг ЭЗЭН жигшдэг бөгөөд түүнийг хийж, нууцаар босгогч хүн нь хараагдсан” гэхэд бүх ард түмэн хариуд нь “Амен” гэнэ.

¹⁵“Урчуудын сийлсэн, эсвэл цутгасан шүтээнийг ЭЗЭН жигшдэг бөгөөд түүнийг хийж, нууцаар босгогч хүн нь хараагдсан” гэхэд бүх ард түмэн хариуд нь “Амен” гэнэ.

¹⁶“Эцэг эхээ хүндэлдэггүй хүн нь хараагдсан” гэхэд бүх ард түмэн “Амен” гэнэ. ¹⁷“Хөршийнхөө шавыг хөдөлгөдөг хүн нь хараагдсан” гэхэд бүх ард түмэн “Амен” гэнэ.

¹⁸“Сохор хүнийг замаас нь төөрүүлэгч хүн нь хараагдсан” гэхэд бүх ард түмэн “Амен” гэнэ. ¹⁹“Харийн хүн, өнчин хүн, бэлэвсэн эмэгтэйг хилс шүүгч хүн нь хараагдсан” гэхэд бүх ард түмэн “Амен” гэнэ. ²⁰“Эцгийнхээ эхнэртэй унтаж, эцгийнхээ хормойг сөхөгч хүн нь хараагдсан” гэхэд бүх ард түмэн “Амен” гэнэ. ²¹“Аливаа мал адгуустай явалдагч хүн нь хараагдсан” гэхэд бүх ард түмэн “Амен” гэнэ. ²²“Өөрийн эгч дүү буюу эцгийнхээ, эсвэл эхийнхээ охинтой унтдаг хүн нь хараагдсан” гэхэд бүх ард түмэн “Амен” гэнэ. ²³“Хадам эхтэйгээ унтдаг хүн нь хараагдсан” гэхэд бүх ард түмэн

“Амен” гэнэ. ²⁴“Хөршөө нууцаар алдаг хүн нь хараагдсан” гэхэд бүх ард түмэн “Амен” гэнэ.

²⁵“Гэмгүй хүнийг алахаар хахууль авагч хүн нь хараагдсан” гэхэд бүх ард түмэн “Амен” гэнэ.

²⁶“Энэ хуулийн бүх үгийг үйлдэн гүйцэтгэдэггүй хүн нь хараагдсан” гэхэд бүх ард түмэн “Амен” гэнэ. (Дэд хууль 27:9-26 АБ 2004)

[] Бурханы эрх мэдэлтэй хүний тунхагласан үг биелэгдэж дуусах хүртлээ талаар өнгөрдөггүй гэдгийг та мэдэх үү?

32.5 Хараал

Яагаад бүх зүйлийг нэг дор биш, бага багаар устгадаг вэ? Энэ нь танд суралцах, эргэж ирэх, ивээл ерөөл авах боломжийг олгодог. (Эцэгийн хайраар дүүрэн зүрх сэтгэл нь хаанчлалаасаа урваж, бузарладаггүй). Хэрэв та өөрийн Бурхан ЭЗЭНийг дуулгавартай дагадаггүй, өнөөдөр танд өгч буй Түүний бүх зарлиг, тушаалыг анхааралтай дагахгүй бол энэ бүх хараал ирэх болно.

1) Чи хотод ч , хөдөөд ч хараагдах болно. Сагс, зангидсан саваа хараагдах болно. Хэвлий дэхь үр болон газрын ургац, мал сүргийн төл, хонин сүргийн хурганууд чинь хараагдах болно. Орохдоо ч гарахдаа ч хараагдах болно.

2) Түүнийг орхисон бузар муу үйлдлийн улмаас болж устгагдаж гэнэт сүйрэх хүртэл нь ЭЗЭН та нар дээр хараал, төөрөгдлийг болон өөрийн гараар хийж буй бүх зүйл дээр чинь зэмлэлийг авчирна.

3) Эзэмшихээр орж буй газар нутгаас устгах хүртлээ ЭЗЭН чамайг өвчин тахалд нэрвэгдүүлнэ.

4) ЭЗЭН таныг үргүйдэл, халууралт, үрэвсэл зэрэг өвчнөөр, аагим халуун ган гачиг, хортон шавьж, хөгцөөр сүйрүүлнэ. Толгой дээрх тэнгэр хүрэл болж , доорх газар чинь төмөр байх болно.

5) ЭЗЭН нутгийн чинь бороог тоос, үнс болгож энэ нь чамайг устгах хүртэл тэнгэрээс буун ирнэ. ЭЗЭН чамайг дайснуудынхаа өмнө ялагдах шалтгаан болгоно. Та нар

тэдэн рүү нэг зүгээс ирэх боловч тэднээс долоон замаар зугтааж, та нар дэлхий дээрх бүх хаанчлалд ад үзэгдэнэ. Чиний хүүр нь огторгуйн бүх шувууд, газрын араатан амьта ын хоол болох бөгөөд тэднийг хэн ч үргээж айлгахгүй.

6. ЭЗЭН чамайг Египетийн хатиг, шамбарам, яр шарх, хамуу өвчнөөр цохих бөгөөд чи эдгэрч чадахгүй.

7) ЭЗЭН чамайг галзуурал, оюун санааны төөрөгдөлд зовооно. Сохор хүн харанхуйд тэмтчихийн адил чи гэгээн цагаан өдөр ч тэмтчин, зам мөр чинь бүтэмжгүй, чи дандаа дарлагдан дээрэмдүүлж, хэн ч чамайг аврахгүй.

8) Чи бүсгүй хүнд сүй тавих боловч өөр хүн түүнийг чинь хүчирхийлнэ.

9) Чи байшин барих боловч түүндээ суухгүй, чи усан үзмийн цэцэрлэг тариалах боловч үр жимсийг нь хүртэхгүй. Чи байшин барих боловч түүндээ суухгүй, чи усан үзмийн цэцэрлэг тариалах боловч үр жимсийг нь хүртэхгүй

10) Чиний үхрийг нүдний чинь өмнө нядлах боловч чи түүнээс идэж чадахгүй. Чиний илжгийг улаан нүүрэн дээр чинь булаах боловч чи түүнийг буцааж авч чадахгүй. Чи хонио дайснуудад алдах боловч чамд туслах хэн ч байхгүй

11) Чи хөвгүүд, охидоо өөр ард түмнүүдэд алдаж, өдөржин тэдний хойноос харуулдсаар нүд чинь сүүмийж, гар чинь ямар ч хүч чадалгүй болно

12) . Газрын чинь ургац, ажил хөдөлмөрийн чинь үр жимсийг чиний таньж мэдэхгүй үндэстэн идэж, чи үргэлж дарлагдан нухлагдана.

13) Тиймээс чи үзэж харсан бүхнээсээ болоод галзуурна. ЭЗЭН өвдөг, хөлийг чинь эдгэшгүй хатиг яранд бариулж, та нар хөлийнхөө улнаас толгойнхоо оройг хүртэл шавсан тэр хатиг ярнаасаа ангижирч чадахгүй.

14) ЭЗЭН чамайг болон чиний дээрээ залах хааныг чиний болон өвөг дээдсийн чинь таньж мэдэхгүй улс үндэстэн уруу аваачна. Чи тэнд мод, чулуугаар хийсэн өөр бурхдад

зарагдана. ³⁷ЭЗЭН чамайг хөөн аваачих бүх үндэстний дунд чи адлагдан, зүйр үг, хэл амны бай болно. ЭЗЭН таныг болон таны тогтоосон хааныг жолоодно

15) Чи талбайдаа арвин үр суулгах боловч царцаанд идүүлсний улмаас бага ургац авна.

16). Чи усан үзэм тарьж ургуулах боловч өтөнд идүүлсний улмаас усан үзэм ч авч чадахгүй, дарс ч ууж чадахгүй

17) Чиний бүх газар нутаг дээр чидун жимсний мод байх боловч жимс нь унаснаас болоод, тосоор нь биеэ тосолж чадахгүй Та нар бүхлээрээ чидун модтой болно

18) Чи хөвгүүд охид төрүүлэх боловч тэд олзлогдох тул чамтай хамт байж чадахгүй.

19) Чиний бүх мод, газрын чинь ургацыг голионууд эзэмшинэ. ⁴³Та нарын дунд байгаа харийн хүн чамаас дээшилж, улам улам дэвшин, чи улам улам буурна.

20)Тэрээр чамд зээл өгнө. Харин чи түүнд зээл өгч чадахгүй. Тэр толгой болж, чи сүүл болно.

Израилийн түүхэнд үйлдсэн тэмдгүүд болон гайхамшгуудаас мэдэгтүн

⁴⁵Чи ЭЗЭН Бурханыхаа үгийг дагаж, Түүний чамд тушаасан зарлиг тушаалыг сахиагүй учир энэ бүх хараал чам дээр бууж, чамайг нэхэн дагасаар эцэст нь чамайг устгана.

⁴⁶Тэр бүх хараал чамд болон чиний үр хүүхдүүдэд тэмдэг, гайхшрал болж үүрд байна. ⁴⁷Чи алив бүхнээр элбэг дэлбэг байсан ч гэсэн ЭЗЭН Бурхандаа баяр хөөртэй зүрх сэтгэлээр зарагдаагүй учраас ⁴⁸ЭЗЭНээс чиний эсрэг илгээх дайснуудад чи өлсөж цанган, нүцгэрч, алив бүхнээр дутагдан байж зарагдана.

Тэр чамайг устгах хүртэл хүзүүнд чинь төмөр буулга углана. ⁴⁹ЭЗЭН алсаас, газар дэлхийн хязгаараас хэл нь чамд үл ойлгогдох нэг үндэстнийг бүргэдийн шүүрэлт мэт чам уруу авчирна. ⁵⁰Тэр үндэстэн бол ширүүн догшин царайтай бөгөөд настныг үл хүндэлж, хүүхдийг эс өрөвддөг. ⁵¹Тэд чамайг

устгах хүртэл малын чинь төл, газрын ургацыг чинь иднэ. Тэд бас чамайг мөхтөл тариа будаа, дарс, тос, үхэр, хонины төлийг чамд үлдээхгүй.

⁵²Тэд чиний найдвар болсон өндөр, бат бэх хана хэрмүүдийг нуран унах хүртэл чамайг газар нутаг дээрх бүх хотуудад чинь бүсэлнэ. Тэд ЭЗЭН Бурханаас чинь чамд өгсөн газрын бүх хотуудад чамайг бүслэх болно. ⁵³Чи дайснууддаа бүслэгдэж шахагдан зовох үедээ, ЭЗЭН Бурханаас чамд хайрлаж, бие махбодоос чинь тасран гарсан үр хүүхдийнхээ, хөвгүүд охидынхоо махыг иднэ.

⁵⁴Та нарын дунд маш эмзэг зөөлөн сэтгэлтэй эр байсан ч гэсэн тэрээр ах дүү, хайртай эхнэр, амьд үлдсэн хүүхдүүддээ ч өсөрхөн, ⁵⁵өөрийн идэх хүүхдийнхээ махнаас тэдний хэнд нь ч өгөхгүй. Чиний дайснууд бүх хотуудыг чинь бүслэн, зовоон, түүнд юу ч үлдээгээгүй учраас тэр юм. ⁵⁶Мөн та нарын дунд эмзэг зөөлөн сэтгэлтэй бүсгүй, газар шороон дээр хөлөө ч тавьж үзээгүй тийм эмзэг зөөлөн сэтгэлтэй бүсгүй байлаа ч гэсэн хайртай нөхөр, хүү охиндоо өсөрхөн, ⁵⁷хөлийн хоорондоос нь унжих эхэсээ төрсөн үртэйгээ хамт нууцаар иднэ. Чиний дайснууд бүх хотуудыг чинь бүслэн, зовоон, тэрээр юу ч олоогүй учраас тэр юм. ⁵⁸Хэрэв чи энэ номд бичигдсэн хуулийн бүх үгийг чиний Бурхан ЭЗЭН хэмээх энэ эрхэм, сүрдмээр нэрээс айн эмээхийн тулд хичээнгүйлэн дагахгүй бол ⁵⁹ЭЗЭН чиний гай гамшиг, чиний үр удмын гай гамшгийг аймшигтай болгож, тэр нь улам бүр хүндрэн удаан үргэлжлэх гай гамшиг, муухай ужиг өвчин болно. ⁶⁰ЭЗЭН чиний айж байсан Египетийн бүх өвчнийг чам дээр буцаан авчирч, тэдгээр нь чамайг нэрвэнэ. ⁶¹ЭЗЭН бас энэхүү хуулийн номд бичигдээгүй бүх өвчин, бүх тахлыг чамайг устгал чинь чам дээр авчирна. ⁶²Та нар тэнгэрийн одод шиг тоо томшгүй олон байсан ч ЭЗЭН Бурханыхаа үгийг дагаагүй учраас хэдүүлхнээ болж үлдэнэ.

⁶³ЭЗЭН та нарыг сайн сайхан, өнөр өтгөн болгохдоо баярласан шигээ та нарыг устган сөнөөхдөө баярлах болно. Та нар эзэмшихээр очиж буй тэр газраасаа хагацна. ⁶⁴ЭЗЭН чамайг газар дэлхийн нэг өнцгөөс нөгөө өнцөг хүртэл бүх ард түмнүүдийн дунд тараах болно. Тэнд чи өөрөө ч мэдэхгүй, өвөг дээдэс чинь ч мэдэхгүй мод, чулуун бурхдад зарагдах болно. ⁶⁵Чи тэдгээр үндэстний дотор амар амгаланг олж чадахгүй, хөлөө амраах газар ч олж чадахгүй.

Харин тэнд ЭЗЭН зүрхийг чинь чичрүүлж, зовхийг чинь буулган, сэтгэлийг чинь самууруулна. ⁶⁶Амь амьдрал чинь дээсэн дөрөөн дээр тогтож, өдөр шөнөгүй айж эмээн, амьдралдаа ямар ч итгэлгүй байх болно. ⁶⁷Зүрхний айдас, үзсэн харсан зүйлээсээ болоод чи өглөө нь “Орой болоосой”, орой нь “Ээ, өглөө болоосой” гэх болно. ⁶⁸Миний чамд “Чи үүнийг дахин хэзээ ч үзэхгүй” гэж өмнө нь хэлсэн тэр замаар ЭЗЭН чамайг хөлөг онгоцоор Египетэд буцааж аваачна. Тэнд та нар өөрсдийгөө дайснууддаа боол шивэгчид болгон худалдах гэсэн ч хэн ч та нарыг авахгүй гэв. (Дэд хууль 28:45-68 АБ 2004)

²⁰Есүс шавь нарын зүг харцаа хандуулан -Ядуус та нар ерөөлтэй ээ! Учир нь Бурханы хаанчлал та нарынх юм. ²¹Эдүгээ өлсөж буй та нар ерөөлтэй ээ! Учир нь та нар цатгагдах болно. Эдүгээ гашуудан уйлж буй та нар ерөөлтэй ээ! Учир нь та нар инээх болно. ²²Хүний Хүүгээс болж хүмүүс та нарыг үзэн ядаж, хавчин, доромжилж, нэрийг чинь хорон муу мэтээр үзэж үл ойшоох цагт та нар ерөөлтэй ээ! (Лук 6:20-22 АБ 2004)

²⁴Харин баячууд та нар золгүй ээ! Та нар тайвширлаа дүүрнээр хүлээн авсан. ²⁵Эдүгээ цатгалан буй та нар золгүй ээ! Учир нь та нар өлсөх болно. Эдүгээ инээж буй та нар золгүй ээ! Учир нь та нар гашуудан уйлах болно. ²⁶Бүх хүмүүс та нарын тухай сайнаар ярих цагт та нар золгүй ээ! Учир нь тэдний эцэг өвгөд хуурамч эш үзүүлэгчдэд ч тэгж хандсан юм. (Лук 6:24-26 АБ 2004)

²⁶Хэрэв бид үнэний мэдлэгийг хүлээн авсны дараа санаатайгаар нүгэл үйлдвэл нүглийн төлөөх тахил цаашид үлдэхгүй. ²⁷Харин шүүлт хийгээд эсэргүүцэгчдийг шатаах галын хилэнг айн чичирч хүлээх нь үлдэнэ. ²⁸Мосегийн Хуулийг үл хэрэгсэгч хүн хоёр буюу гурван гэрчийн гэрчлэлээр өршөөлгүй үхдэг. ²⁹Бурханы Хүүг уландаа гишгэж, өөрийг нь ариусгасан гэрээний цусыг бузар хэмээн үзээд нигүүлслийн Сүнснийг доромжилсон хүн хэр зэрэг илүү хүнд шийтгэл эдэлбэл зохино гэж та нар бодож байна? ³⁰Учир нь “Өшөө авалт нь Минийх. Хариуг нь Би өгнө” гээд, дахиж “Эзэн Өөрийн хүмүүсийг шүүнэ” гэж айлдсан Түүнийг бид мэднэ. ³¹Амьд Бурханы гарт орох нь аймшигтай хэрэг мөн. (Еврей 10:26-31 АБ 2004)

[] Бузар муу нь яагаад таны төсөөлөхөөс ч дор байдгийг та мэдэх үү?

[] Боол ямар тэмдэгтэйг та мэдэх үү?

[] Хэн ерөөгдөж , хэн хараагддаг болохыг та мэдэх үү ?

[] Түүний эсрэг үйлдэл бүр шүүгдэх болно гэдгийг та мэдэх үү ?

32.6 Гэм буруутай нь тогтоогджээ

⁶“Үзэгтүн, энэ нь Миний өмнө бичигдсэн. Би дуугүй байхгүй, харин буцааж төлнө. Түүгээр ч үл барам Би тэдний өвөрт нь төлнө. (Исаиа 65:6 АБ 2004)

³Чиний нүцгэн бие ил гарч, чиний ичгүүр ч бас үзэгдэх болно.Би нэг ч хүнийг өршөөхгүйгээр өшөө авна”. (Исаиа 47:3 АБ 2004)

32.6.1 Шударга ёс үгүй

²Иерусалимын зүрхэнд эелдэг ярь. Түүний хүнд хүчир үүрэг дууссан,гүүний хилэнц зайлуулагдсан. Тэр бүх л нүглийнхээ төлөө ЭЗЭНий мутраас хоёр дахин хүлээн авсан гэдгийг хэлэгтүн. (Исаиа 40:2 АБ 2004)

⁹Ийм учраас шударга ёс биднээс хол, үнэн зөв нь бидэнд хүрэхгүй. Бид гэрлийг хайдаг боловч харанхуйг л хардаг, хурц гэрлийг хүлээвч, бүрэнхийд алхдаг. ¹⁰Бид сохор хүмүүс мэт хана дагуу тэмтрэн,нүдгүй хүмүүс адил тэмтэчнэ. Үд дунд бид бүрэнхийд мэт бүдэрч,хүчтэнүүдийн дунд бид хүүр мэт байна. ¹¹Бид бүгдээрээ баавгай мэт хүрхрэн, тагтаа мэт гашуудна. Бид шударга ёсыг хайвч, тэр нь алга.Авралыг хүлээвч, тэр нь биднээс хол ажээ. (Исаиа 59:9-11 АБ 2004)

Бурхан нүгэлтнүүдийн хүсэлтийг хариулахгүй. Бид эхлээд гэм нүглээ наманчилж, тэнцсэн байх ёстой.

[] Таньд гэмшээгүй нүгэл бий юү?

32.6.2 Итгэлт хот янхан болжээ

²¹Итгэмжит хот яаж янхан болсон бэ? Зөв шударгаар дүүрэн, энд үнэн зөв хоноглодог байсан атал, харин одоо алуурчдаар л дүүрчээ. ²²Чиний мөнгө хог болсон. Чиний дарс усаар шингэлэгдсэн.

²³Чиний ноёд бол бослого гаргагчид, хулгайчдын найзууд. Хүн бүр хахуульд дуртай бөгөөд шан харамж хөөцөлддөг. Тэд өнчнийг хамгаалдаггүй, бэлэвсний өргөдлийг хүлээн авдаггүй.

²⁴Тийм учраас түмэн цэргийн БУРХАН Эзэн, Израилийн Хүчит Нэгэн тунхаглаж байна. “Аяа, Намайг эсэргүүцэгчдээс Би чөлөөлөгдөж, дайснуудаас Өөрийнхөө өшөөг авна. ²⁵Би бас мутраа чиний эсрэг эргүүлж, чиний хогийг бүхэлд нь шүлтэд хийх мэт цэвэршүүлж, бүх хольцыг чинь зайлуулна. (Исаиа 1:21-25 АБ 2004)

32.6.3 Бурханаас ямар ч үг алга

⁴Иймээс “Би Өөрийн орших газраас гэрэл доторх гялалзсан халуун мэт, ургац хураах үеийн аагим халуун шиг, шүүдрийн үүл мэт тайван харж байх болно” гэж ЭЗЭН надад айлдав. (Исаиа 18:4 АБ 2004)

[] Наманчлах гэдэг нь Түүний үгсийг зүрх сэтгэлдээ урьж байгаа хэрэг юм. Үг нь таныг гэмшилд дуудахад та гэмшдэг үү?

32.6.4 Тохуурхагчид хойшоо унана

⁹“Тэр хэнд мэдлэг заах болж байна вэ? Тэр хэнд сургаалыг ойлгуулах болж байна вэ? Сүүнээс гарсан хүүхдэд үү, хөхнөөсөө салсан хүүхдэд үү?”

¹⁰Учир нь тэр “Тушаалын дээр тушаал, тушаалын дээр тушаал, журам дээр журам, журам дээр журам. Энд жаахан, тэнд жаахан” гэж байна”. ¹¹Үнэхээр Тэр энэ ард түмэнд хандаж шулганасан уруул, харь хэлээр дамжуулан ярих болно. ¹²Тэр эдэнд хандан, “Энд амралт байна. Эцэж туйлдагсдад амралтыг өгөгтүн. Энд айван байна” гэсэн боловчтэд сонсохгүй байх юм.

¹³Иймээс тэдэнд айлдах ЭЗЭНий үг нь “Тушаалын дээр тушаал, тушаалын дээр тушаал, журам дээр журам, журам дээр журам. Энд жаахан, тэнд жаахан” гэнэ. Энэ нь тэд явж, гэдрэг бүдрэн, эвдрээд, урхинд орж баригдахын тулд юм. ¹⁴Тиймээс Иерусалим дахь энэ ард түмнийг захирагч, шооч хүмүүс ээ. ЭЗЭНий үгийг сонсогтун. ¹⁵Учир нь та нар “Бид үхэлтэй гэрээ байгуулсан, бид Үхэгсдийн оронтой хэлэлцээр хийсэн. Дийлдэшгүй ташуур дайран өнгөрөхдөө бидэнд хүрэхгүй. Учир нь бид худал хуурмагийг өөрсдийн хоргодох газар болгож, заль мэхээр өөрсдийгөө далдалсан” гэж хэлсэн. (Исаиа 28:9-15 АБ 2004)

[] Үхлийн гэрээ гэж юу болохыг та мэдэх үү?

32.6.5 Орхигдсон, орхигдсон

⁷“Би Өөрийн гэрийг орхиж, Өөрийн өвийг хаяв. Би сэтгэлийнхээ хайртыг дайснуудынх нь гарт өгөв. (Иеремиа 12:7 АБ 2004)

⁸ЭЗЭН үүнийг айлдаж байна. “Хонхорцог дотор шинэ дарс олдвол “Түүнийг бүү устгагтун. Түүнд ивээл байна” хэмээн хүн өгүүлдэг мэт, Би Өөрийн боолуудын төлөө үйлдэж, тэднийг бүгдийг нь устгахгүй. (Исаиа 65:8 АБ 2004)

¹⁴Би тэднийг эцгүүд болон хөвгүүдийнх нь хамт бие биенийх нь эсрэг бут цохино” гэж ЭЗЭН тунхаглаж байна. “Би тэднийг өрөвдөх ч үгүй, харамсах ч үгүй, энэрэх ч үгүй устгана” хэмээв” гэж хэл” гэжээ. (Иеремиа 13:14 АБ 2004)

¹⁷Харин чи үүнийг сонсохгүй бол миний сэтгэл бардам зангийн өмнөөс нууцгайлан уйлна. ЭЗЭНий сүрэг олзлогдсон тул миний нүд гашуунаар уйлж, нулимс урсгана. (Иеремиа 13:17 АБ 2004)

¹²Тэднийг мацаг барихад Би тэдний орилохыг сонсохгүй. Тэднийг шатаалт тахил болон идээн өргөлийг өргөхөд Би тэднийг хүлээн авахгүй. Харин Би илд, өлсгөлөн болон тахлаар тэднийг төгсгөл болгоно” гэж айлдав. (Иеремиа 14:12 АБ 2004)

⁶ЭЗЭН тунхаглаж байна. “Намайг орхисон чи арагшаа явсаар л байна. Тиймээс Би чиний эсрэг гараа сунгаж, чамайг устгана. Би зөөлөн хандсаар байгаад залхжээ. (Иеремиа 15:6 АБ 2004)

⁷Би тэднийг газар нутгийн дааман хаалганы дэргэд шигшигч сэрээгээр шигшинэ. Би хүүхдүүдээс нь хагацааж, Өөрийн ард түмнийг Би устгана. (Иеремиа 15:7 АБ 2004

⁸Тэдний бэлэвсрэгсэд нь Миний өмнө далайн эргийн элснээс ч илүү олон болно. Бид тэдний эсрэг буюу залуу хүний эхийн эсрэг үд дунд сүйтгэгчийг авчирна. Би түүн дээр айдас, зовлонг гэнэт авчирна. (Иеремиа 15:8 АБ 2004

32.6.6 Тэрслүү ард түмэн

²Аяа, тэнгэр минь, сонсогтун. Газар минь, чих тавигтун. ЭЗЭН айлдаж байна. “Миний өсгөж, торниулсан хөвгүүд Миний эсрэг бослоо.³Шар өөрийн эзнээ таньдаг. Илжиг ч эзнийхээ тэвшийг таньдаг. Харин Израиль мэддэггүй. Миний хүмүүс ойлгодоггүй”.

⁴Ээ халаг, нүгэлт үндэстэн, гэмд дарагдсан ард түмэн, хорлогчдын үр удам, ялзарсан хөвгүүд. Тэд ЭЗЭНийг орхилоо. Тэд Израилийн Ариун Нэгэнийг жигшин, Түүнээс гэдрэг эргэлээ.

⁵Та нар урваж шарвасаар дахин хаанаа цохиулмаар байна? Толгой нь бүхэлдээ өвчтэй, зүрх нь бүхэлдээ ядруу байна.

⁶Хөлийн улнаас толгой хүртлээ эрүүл газар алга. Шахаагүй, боогоогүй, тосоор зөөллөөгүй шарх, сорви, өмхий яр л байна.

⁷Та нарын газар эзгүйрч, та нарын хотууд галд шатаж, тариан талбайг чинь та нарын нүүрэн дээр харийнхан залгиж байна. Харийнхнаар устгагдсан хоосрол. ⁸Усан үзмийн талбай дахь нуувч, өргөст хэмхний талбай дахь манаачийн овоохой болон бүслэгдсэн хот мэт Сионы охин орхигдов.

⁹Хэрэв түмэн цэргийн ЭЗЭН цөөн хүмүүсийг бидэнд амьд үлдээгээгүй бол бид Содомтой адил болж, Гоморратай төстэй байцгаах байсан. (Исаиа 1:2-9 АБ 2004

32.6.7 Та нар бол сохор

¹⁸Дүлий хүмүүс ээ, сонсогтун! Сохор хүмүүс ээ, үзэхийн тулд харрагтун! ¹⁹Миний боолоос өөр сохор хүн хэн бэ? Миний илгээсэн элчийн адил дүлий нь хэн бэ? Надтай эв найрамдалтай байдаг хүн шиг сохор, ЭЗЭНий боолын адил сохор хүн хэн бэ?

²⁰Та нар олон юмсыг үзсэн боловч ажиглаагүй. Та нарын чих сонсголтой боловч юуг ч сонсоогүй. ²¹Өөрийнхөө үнэн зөвийн төлөө хуулийг агуу их, алдартай болгох нь ЭЗЭНд таатай байдаг.

²²Гэвч энэ бол тонуулж, дээрэмдүүлсэн ард түмэн. Тэд бүгдээрээ нүхэнд унаж, эсвэл шоронд хадагдсан. Тэд олз болсон. Тэднийг хэн ч чөлөөлөхгүй. Тэд дээрэмдүүлсэн боловч хэн ч “Буцааж өг” гэж хэлэхгүй. ²³Та нарын дотроос хэн нь үүнийг чагнах вэ? Хэн нь ирээдүйд анхаарал тавьж, сонсох юм бэ?

²⁴Хэн Иаковыг олз болгож, Израилийг дээрэмчдэд өгсөн бэ? ЭЗЭН биш гэж үү? Учир нь бид Түүний эсрэг нүгэл үйлдсэн.

Тэд Түүний замаар явахыг хүссэнгүй, Түүний хуулийг дагаагүй. ²⁵Тийм учраас Тэр Өөрийн уур хилэнгийн ааг омгийг, хатуу ширүүн дайныг тэдний дээр асгав. Тэднийг бүх талаас нь галдсан боловч тэд ойлгосонгүй. Тэднийг шатаасан боловч тэд зүрхэндээ үүнийг мэдэрсэнгүй. (Исаиа 42:18-25 АБ 2004)

[] Та нар ийм шүүлт авах хүнийг мэдэх үү?

[] Та болон эргэн тойронд чинь байгаа хүмүүс буруу шийдвэр гаргаж байна уу?

32.6.8 Та хоёр дахин төлнө

⁸Тэд Миний газар нутгийг бузарласан тул Би эхлээд тэдний гэм буруу болон нүглийг давхар төлнө. Тэд Миний өвийг өөрсдийн жигшүүрт шүтээнүүдийн хүүрүүдээр болон өөрсдийн жигшүүрт зүйлээр дүүргэжээ”. (Иеремиа 16:8 АБ 2004)

⁴Тэр өдөр, Иаковын алдар ч буурч, түүний тарган бие туранхай болно. ⁵Энэ нь тариачин тариаг хураахтай, Рефаимын хөндийд тариан түрүүг түүхтэй адил байх болно. ⁶Чидун жимсний модыг цохиход, хамгийн дээд мөчрийн оройд хоёр гурван чидун, дөрөв таван жимстэй хамгийн сайн мөчир үлддэгийн адил тарианы хэсэг түрүү үлдэнэ гэж Израилийн Бурхан, ЭЗЭН зарлиг болов. (Исаиа 17:4-6 АБ 2004)

32.6.9 Бурханы төлөвлөгөө биш зүйлийг хийх

¹“Нүгэл дээр нүглийг нэмэхийн тулд Надгүйгээр төлөвлөж, Миний Сүнсний оролцоогүйгээр ундаан өргөлийг асгагч, дуулгаваргүй хөвгүүд гаслантай яа” гэж ЭЗЭН айлдаж байна. ²Тэд Надтай зөвлөлгүйгээр “Фараоны хамгаалтад хоргодохоор Египетийн сүүдэрт орогнох газар хайн Египет уруу явсан.

³Гэвч Фараоны хамгаалалт нь та нарын ичгүүр болно. Египетийн сүүдэрт орогнох нь та нарын гутамшиг болно. ⁴Учир нь тэдний ноёд нь Зоанд байгаа бөгөөд тэдний элчингүүд нь Ханест хүрч ирсэн. ⁵Өөрсдөд нь тусламж, ашиг болохгүй, харин ичгүүр зэмлэл болох, ашиггүй хүмүүсээс болж хүн бүр ичих болно. (Исаиа 30:1-5 АБ 2004)

32.6.10 Бурханаас биш, Египетээс тусламж хүссэн

¹Израилийн Ариун Нэгэн уруу харалгүй, ЭЗЭНийг хайлгүй, харин Египет уруу тусламж гуйн одож, морьдод түшиглэн тэдний тэрэгнийх нь олонд, морьтонгуудынх нь хүчтэйд найдагч нар гаслантай яа.

²Гэвч Тэр бас мэргэн бөгөөд аюул гамшгийг авчирна. Тэр Өөрийн үгийг өөрчилдөггүй. Харин Тэр нүгэл үйлдэгчийн гэрийн эсрэг, нүгэлтнүүдэд тусалдаг хүмүүсийн эсрэг босох болно. ³Египетчүүд бол Бурхан биш, хүмүүс билээ. Тэдний морьд нь сүнс биш, махан бие билээ. Тиймээс ЭЗЭН мутраа сунгахад туслагч нь бүдэрч, туслуулагчид нь унаж, тэд бүгдээрээ хамт үхнэ. (Исаиа 31:1-3 АБ 2004)

32.6.11 Жигшүүрт зүйл идэх

¹⁷“Гахайн мах, бузар юмс, хулгана иддэг бөгөөд голдоо буй нэгнийг дагаж, цэцэрлэг уруу очиж, өөрсдийгөө ариусган цэвэршүүлэгчид бүгдээрээ эцэс болно” гэж ЭЗЭН тунхаглаж байна. ¹⁸“Учир нь Би тэдний үйлс хийгээд бодлуудыг мэднэ. Бүх үндэстэн, хэлтнийг цуглуулах цаг ирж байна. Тэд ирж, Миний цог жавхланг үзнэ. (Исаиа 66:17-18 АБ 2004)

[] Та сүм дотор аливаа зүйлийг өөрийнхөөрөө хийх нь дуулгаваргүй байдлын нүгэл мэддэг үү?

[] Та бусдад хэрхэн зөв туслахаа мэддэг үү?

[] Бурхан яагаад өөрийн хүмүүст хоол ундны дэглэм өгснийг та мэдэх үү?

32.6.12 Нүдэндээ бардам эмэгтэйчүүд

¹⁶ЭЗЭН ийнхүү айлдав. “Сионы охид бардам учраас толгойгоо өргөн, өдсөн харцаар ширтэн алхаж, хөлийн бугуйвчаа хүртэл жингэнүүлэн ихэмсгээр алхаж байна.

¹⁷Ийм учраас Эзэн Сионы охидын хуйхыг нь яршуулан зовооно. ЭЗЭН тэдний магнайг нь нүцгэлнэ”. ¹⁸Тэр өдөр Эзэн тэдний хөлийн бугуйвч, толгойн зүүлт, саран хэлбэртэй чимэглэл, ¹⁹ээмэг, бугуйвч, гивлүүр, ²⁰малгай, хөлийн гинж, бүс, сүрчигний хайрцаг, сахиус, ²¹хурууны бөгж, хамрын гархи, ²²ёслолын хувцас, гадуур цамц, нөмрөг, мөнгөний түрийвч, ²³толь, дотуур хувцас, алчуур, гивлүүр зэргийг бүгдийг нь авч хаяна. ²⁴Анхилуун сүрчгийг өмхий ус, бүсийг олс, гоёмсог зассан үсийг үс нь халцарсан хуйх, сайхан хувцсыг тааран өмсгөл, үзэсгэлэн гоог ичгүүрийн тамга орлоно.

²⁵Танай эрчүүд илдэнд, танай хүчтэнүүд дайнд унана. ²⁶Түүний дааман хаалганууд гашуудан уйлж, хаягдсан тэрээр газар дээр сууна. (Исаиа 3:16-26 АБ 2004)

32.6.13 Гэм нүглээ дэлгэх

⁹Тэдний царайны хувирал өөрсдийнх нь эсрэг гэрчилдэг. Тэд Содом шиг өөрсдийн нүглээ далдлалгүй дэлгэн үзүүлдэг. Өөрсдийнхөө дээр бузар мууг авчирсан тэд золгүй еэ!

¹²Ард түмэн минь! Хүүхдүүд тэднийг дарлаж, эмэгтэйчүүд тэднийг захирдаг. Ард түмэн минь, та нарыг дагуулагчид та нарыг төөрүүлж, замыг чинь будлиулж байна. (Исаиа 3:9,12 АБ 2004)

[] Бардам зүрхний ямар нийтлэг шинж чанаруудыг та мэдэх вэ ?

[] Хүнд хэцүү үед хүмүүсийг удирдаж байсан Мосе Иосеф хоёр шиг удирдагчдыг бий болгохын төлөө Бурханд залбирдаг уу?

32.6.14 Та хэнийг элэглэж байна вэ?

¹Зөв шударга хүн мөхдөг, үүнийг хэн ч зүрхэндээ авдаггүй. Сүсэгтэй хүмүүсийг авч явахад хэн ч үл ойлгоно. Зөв шударга хүнийг муугаас холдуулж, ²амар амгаланд аваачна. Зөв замаар явагч хүн бүр өөрсдийн хэвтэртээ амарна. ³Харин илбэчин эмийн хөвгүүд, садар самуун, янхнуудын үр сад аа, нааш ирэгтүн. ⁴Та нар хэнийг шоолж, хэний эсрэг амаа томоор ангайлган, хэлээ гаргана вэ? Та нар тэрслэгчийн хүүхдүүд, худал хуурмагийн үр удам бөгөөд ⁵царс моддын дунд, аливаа саглагар модны дор дүрэлзэн шатаж, хадны хавцал дор, гуу жалганд хүүхдээ алдаг биш үү?

⁶Гуу жалгын гөлгөр чулуунуудын дундах нь чиний хувь юм. Тэд, зөвхөн тэд чиний шавга мөн. Чи тэдэнд ундаан өргөл асгаж, идээн өргөл өргөсөн билээ. Үүнд чинь Би санаа амрах болж байна уу? ⁷Чи өндөр, сүрлэг уулан дээр өөртөө ор засаж, тахил өргөхийн тулд тийшээ гарсан. ⁸Чи хаалга хатавчны ард тэмдэг тавьсан.

Үнэндээ Надаас алслан холдсон чи биеэ нүцгэлсэн. Дээш гарч, ороо өргөсгөн, өөрийнхөө төлөө тэдэнтэй тохиролцон, тэдний оронд дурлан, нүцгэн биеийг нь харсан билээ. ⁹Чи хаан уруу тостой очиж, үнэртнээ нэмэгдүүлсэн. Чи элчингүүдээ алс хол газар илгээн, Үхэгсдийн орон уруу буулгасан. ¹⁰Замын уртад чи ядарсан боловч, “Найдлага тасарлаа” гэж хэлээгүй. Чи хүч тэнхээгээ сэргээн олсон учраас шантраагүй. ¹¹“Намайг зүрхэндээ хадгалж дурсалгүй, худал хэлж байхдаа чи хэнээс эмээж зовнисон бэ?

Би удаан хугацааны турш чимээгүй байсан учраас чи Надаас эмээхгүй юу? ¹²Би чиний зөв шударгыг болоод үйлсийг чинь

тунхаглана. Гэвч тэдгээр нь чамд ашиггүй. ¹³Орилж хашхирахад чинь чамайг шүтээний цуглуулга чинь авраг! Харин салхи тэднийг чинь бүгдийг нь хийсгэж, амьсгал ч тэднийг авна. Харин Надад хоргодогч нь газрыг өмчлөн, Миний ариун уулыг эзэмшинэ”.

[] Зөвт хүмүүс энэ дэлхий дээр одоо яагаад мөхдөгийг та мэдэх үү?

[] Бурхан тэднийг яагаад авч оддогийг та мэдэх үү?

[] Нүгэлтнүүдийг Бурхан яагаад тэр даруйд нь шүүдэггүйг та мэдэх үү?